



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Их Сургууль

Хөтөлбөрийн нэр: Гадаад хэлний орчуулга /англи/

Индекс: D023101

Шинжээчийн баг:

Ахлагч: Н. Оюунцэцэг

Гишүүд: Р. Наранцэцэг

Ж. Ганцэцэг

Он сар өдөр: 2023 оны 5-р сарын 5

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Монгол улсын их сургууль National University of Mongolia	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Гадаад хэлний орчуулга /англи хэл/	
<b>Индекс</b>	D023101	
<b>Шинжээчид</b>	Шинжээчийн багийн ахлагч: Н. Оюунцэцэг – Хүмүүнлэгийн Ухааны их сургуулийн Англи хэлний тэнхимийн багш, доктор Шинжээчийн багийн гишүүд: Р. Наранцэцэг – Отгонтэнгэр их сургуулийн Гадаад хэлний тэнхимийн багш, доктор Ж. Ганцэцэг – Шинжлэх Ухаан Технологийн их сургуулийн Гадаад хэлний сургуулийн Англи хэлний тэнхимийн дэд профессор, доктор	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Б. Мядагмаа – БМИҮЗ-ийн Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2023.04.26	МУИС-н Их Британи, Америк судлалын тэнхим дээр шинжээчийн баг очиж ажиллах
		Шинжээчийн баг удирдлага болон ӨҮТ-н багтай уулзах
		Хөтөлбөрийн талаар бэлтгэсэн материал, тайлангийн нотлох баримттай танилцах
		Гадаад хэлний орчуулга (Англи) хөтөлбөрийн оюутнуудтай уулзах
		Гадаад хэлний орчуулга (Англи) хөтөлбөрийн төгсөгчидтэй уулзах
		Гадаад хэлний орчуулга (Англи) хөтөлбөрийн ажил олгогчдын төлөөлөлтэй уулзах
		Гадаад хэлний орчуулга (Англи) хөтөлбөрийн багш нартай уулзах
	2023.04.27	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
		Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх, танилцах
Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ		
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-ийн Шинжлэх Ухааны сургуулийн Хүмүүнлэгийн Ухааны салбарын Их Британи, Америк судлалын тэнхимийн Гадаад хэлний орчуулга (Англи) индекс D023101 хөтөлбөр нь 2014 онд БШУС-н А/78-р тушаалаар батлагдсан хөтөлбөр бөгөөд “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу шинэчлэн боловсруулж 2014-2015 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн хөтөлбөр юм. Нийт 5 удаагийн төгсөлт хийсэн уг хөтөлбөр нь Монгол улсын олон тулгуурт нээлттэй гадаад бодлого, шинжлэх ухаан техник, технологи, нийгэм-эдийн засгийн хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэхэд холбох гүүр болохуйц гадаад хэлний мэдлэгтэй, нийгмийн аль ч салбарт хөрвөх чадвартай, зөв хандлагатай мэргэжилтэн бэлтгэх нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу англи хэлний мэргэжлийн орчуулагчдыг бэлтгэж байна.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим нь 12 багш, 1 гадаад багш, 1 туслах ажилтантайгаар сургалтын үйл ажиллагааг явуулж байна.

## III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөрийн хүрээнд оюутны сэтгэл ханамжийн судалгааг 2018, 2021 онуудад зохион байгуулсан байна. Үр дүн, материалуудтай танилцав.
- Сургуулийн зүгээс төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгааг жил бүр зохион байгуулж хийж хэвшсэн байна. 2019-2021 онд зохион байгуулагдсан төгсөгчдийг мөшгих судалгаагаар танилцав.
- Сургуулийн зүгээс төгсөх түвшний оюутнуудын дунд тухайлсан судалгаа зохион байгуулж тэдний санал, сэтгэгдлийг тодруулдаг байна. Төгсөх түвшний суралцагчийн судалгааны тайлан (2020) -тай танилцав.
- Сургуулийн зүгээс ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг байнга зохион байгуулдаг байна.
- МУИС-н суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан (2018-2019) тайлантай танилцав.

- Тэнхим тус хөтөлбөрийг сайжруулахдаа гадаадын их дээд сургуулийн хөтөлбөрийн бүтэцтэй харьцуулсан судалгаа хийсэн байна. (University of Hong Kong, Orla Roberts University, Gallaudet University). Улмаар дотоодын 1 их сургуультай харьцуулалт хийжээ. (ХИС)
- Гадаад хэлний орчуулга (Англи) хөтөлбөрт STEEP шинжилгээ хийсэн байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтад оролцогч талуудыг хамруулж, хэрэгцээг тодорхойлох судалгааг зохион байгуулж хэвшсэн.
- Олон улсын чиг баримжааг харгалзан сургалтын хөтөлбөрийг сайжруулахад анхаарсан.

#### **Анхаарах асуудал:**

- Хэд хэдэн дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулах

#### **Зөвлөмж:**

- Олон улсад хэрэгжиж буй ижил төрлийн сургалтын хөтөлбөртэй харьцуулах

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд МУИС-ийн алсын хараа нь дэлхийн түвшний их сургууль болох улмаар 2024 он гэхэд МУИС нь чөлөөт мэдлэг буюу либерал арт уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэгүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орно гэсэн байна.
- МУИС нь шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу либерал арт уламжлалд суурилсан хөтөлбөртэй, байгалийн ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт, судалгааны ажлыг тогтвортой эрхэлж, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой академик буюу эрдмийн байгууллага болохоор эрхэм зорилгоо тодорхойлсон.
- МУИС-ийн алсын хараа болон эрхэм зорилгод тусгагдсаны дагуу англи хэлний орчуулагч хөтөлбөрийг либерал арт чиглэл рүү боловсруулан хэрэгжүүлж, улмаар хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх зорилгыг хөтөлбөртөө тусгасан.
- Гадаад хэлний орчуулга /англи хэл/ хөтөлбөрийн зорилго нь “Хэл, соёл, нийгэм, хүмүүнлэгийн салбарт орчин үеийн чиг хандлагад нийцсэн гадаад

хэлний стандартын харгалзах түвшний мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэх” хэмээн тусгасан бөгөөд сургалтын хөтөлбөрийн чанарыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэж, оюутанд өргөн сонголтыг бий болгох МУИС-ийн тэргүүлэх зорилтод хүрч, олон улсын жишиг, өнөөгийн нийгмийн шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ зэргээс шалтгаалан хөрвөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх нь их сургуулийн алсын хараа, эрхэм зорилготой холбогдож байна.

- Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага А/174 (2014.04.28) баримтлаж сургалтын хөтөлбөрийн зорилгыг боловсруулсан.
- МУИС-н сургалтын хөтөлбөрийн журам, сургалтын үйл ажиллагааны журам А/256 (2022.06.27) хөтөлбөрийн зорилгыг боловсруулсан

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн хэмжээнд гадаад хэлний орчуулга хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг (PLO) боловсруулж, хэлний хөтөлбөрт суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг тусган, хэрэгжүүлж байна.

### **Анхаарах асуудал:**

- Сургалтын хөтөлбөр боловсруулах хүрээнд хичээл бүрд төсгөгчийн загвар болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг тусгаж боловсруулахад багш бүрийн оролцоог хангаж ажиллах тал дээр анхаарах хэрэгтэй.

### **Зөвлөмж:**

- Хэдийгээр сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг сургуулийн хэмжээнд тодорхойлж, сургалтын хөтөлбөрийн зорилготой уялдуулж байгаа нь сайшаалттай боловч өөрчлөгдөн буй өнөөгийн нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг бодолцон цаашид хэл бүрийн онцлогт нийцүүлэн сайжруулах хэрэгтэй.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- 2015 оны 8-р сарын 25нд баталсан Сургалтын төлөвлөгөөг сургалтад мөрдлөг болгож байна. Үүнд: Ерөнхий суурь -36, мэргэжлийн суурь хичээл-9, мэргэжлийн заавал судлах-56, Мэргэжлийн сонгон-4, Чөлөөт сонголт-15 багц цаг байна.

- 2020 оны 5-р сарын 13 ны өдөр Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсийн хурлаар хэлэлцэж сургалтын төлөвлөгөөнд 4 хичээл нэмж, өөрчилсөн (сонгон судлах хэлбэрээр) байна. Үүнийг оюутнуудын дунд зохион байгуулсан санал асуулгад нийцүүлэн өөрчилсөн.
- 2018 онд зохион байгуулсан санал асуулгад, үндэслэн ном сурах бичгийг сольж, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.
- Тэнхимийн хөтөлбөрийн хороонд 5 багш ажиллаж, хөтөлбөрт хийх өөрчлөлт, санал, дараагийн шатны хөтөлбөрийн хороодод дамжуулж, хамтран ажилладаг байна.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Чөлөөт сонголтын 15 багц цагийг санал болгож, оюутнуудад хөрвөх чадвартай мэргэжилтэн болох боломжийг бүрдүүлсэн.

### **Анхаарах асуудал:**

- Тэнхимийн хөтөлбөрийн хороо хөтөлбөрийн сайжруулалтын хүрээнд идэвхтэй ажиллаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж, улмаар сайжруулах талаар илүү анхаарч ажиллах хэрэгтэй.

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр сайжруулах, шинэчлэх үйл явцад тэнхимийн хөтөлбөрийн хороо санаачилгатай ажиллаж, багш нарыг татан оролцуулж байх

## **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

### **Илрэл нотолгоо:**

- БСШУ-ны сайдын А/174 тоот тушаал батлагдснаар их, дээд сургууль дээр хэрэгжиж байсан агуулгын давхардал бүхий олон жижиг мэргэжлүүдийг нэгтгэн бүлэглэж, олон улсын жишгийн дагуу Либерал арт уламжлалд суурилсан хөтөлбөрөөр сургалт явуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.

- Гадаад хэлний орчуулга (Англи) хөтөлбөрөөр төгсөгчийн мэдлэг, ур чадвар, хандлага PLO сургуулийн хэмжээнд тодорхойлсон.
- Европын олон хэлний суурь хөтөлбөр (CEFR) дээр үндэслэн оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон
- Сургуулийн хэмжээнд гадаад хэлний сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг тодорхойлсон
- Тус хөтөлбөрийн мэргэжлийн заавал судлах 56 багц цагийн хичээлээс лекцийн буюу онолын хичээл 12 багц цаг (21.5%), практик буюу дадлагын хичээл 44 багц цаг (78.5%)-ийг эзэлж байна. Энэ хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцаа 1:3,4 буюу дадлагын хичээл давамгайлсан харьцаатай байна. Энэ нь орчуулгын хөтөлбөрийн онцлогтой холбоотой бөгөөд орчуулгын мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлыг гол төлөв дадлагын хичээлээр олж авах боломжтой.
- Сонгон судлах нийт 15 багц цагийн хичээлээс 4 багц цагийг сонгон судлах боломжтой бөгөөд сонгон судлах 15 багц цагийн 4 багц цаг нь лекцийн буюу онолын хичээл (27%), 11 багц цаг нь дадлагын хичээл (73%) байна. Сонгон судлах хичээлийн онол, практикийн харьцаа 1:3 байна.
- Хичээлээр олгож буй онолын мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн дадлагыг зохион байгуулдаг. 7-р улиралд 3 баг цагийн дадлага, 6 долоо хоногт хийдэг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн суралцахуйн зорилтыг боловсруулахад тэнхимийн дэд хороогоор хэлэлцэхгүй, багш бүр тусдаа хийж байна.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнг сайжруулан тодорхойлох асуудалд анхаарч ажиллах хэрэгтэй.

### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Бүтээлч, идэвхтэй аргуудыг сургалтад хэрэглэдэг. Хичээлүүдэд өргөн хэрэглэдэг 34 идэвхтэй аргыг хөтөлбөрт тусгасан.
- Синхрон орчуулгын танхимтай, сургалтыг практикт суурилан явуулж байна.
- Хэлний авиа зүйн чиглэлээр судалгаа хийх танхимтай, тус тэнхимийн багш нар судалгаанд оролцдог. Оюутнууд ч судалгаа хийх боломжтой.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**



- Синхрон орчуулгын хичээлийг үр дүнтэй хэрэгжүүлэх лабораторитой. Энэ нь орчуулгын хичээлийн үр дүнг нэмэгдүүлэх боломж юм.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлд идэвхтэй аргуудыг ашигладаг гэсэн боловч хэрхэн яаж хэрэглээд, тодорхой ямар үр дүн хүрсэн эсвэл хүрэх боломжтой талаар тодорхой мэдээлэл харагдахгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Лабораторид түшиглэн орчуулгын хичээлүүдэд сүүлийн үед ихээр хэрэглэгдэх болсон орчуулгын технологи ашиглах, жишээлбэл хиймэл оюун болон машин орчуулгын гэх мэт.

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн сургалтын журмын 2.4 болон 4.6-д суралцагчийн мэдлэг, чадварын үнэлгээний талаар тодорхой тусгасан.
- Журмын 4.6.12.1-т зааснаар тухайн хичээлээр суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргахдаа оюутны хичээлийн идэвх оролцоо буюу хичээлд оролцсон байдал, ирц, семинар, дадлага, хичээлд бэлтгэгдсэн байдал зэрэгт багшийн өгсөн үнэлгээ 40-өөс ихгүй, суралцагчийн явцын үнэлгээ буюу улирлын явцад хийсэн илтгэл, реферат, тайлан, хяналтын ажил, сэдвийн үнэлгээний дундаж болон явцын шалгалтын нийлбэр 60-аас ихгүй, улирлын шалгалт 60-аас ихгүй байна гэж заажээ.
- Хөтөлбөрийн мэргэжлийн хичээлээр болон бие даан гүйцэтгэх ажил, эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг 100 оноогоор дүгнэх бөгөөд түвшнийг 9 баллын системээр хувьчилсан оноо, үсэг, тоон байдлаар илтгэдэг байна.
- МУИС нь бусад сургуулийн багц цагийг тооцох, суралцагч голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох үүднээс үндсэн үнэлгээг хэрэглэхээс гадна нэмэлт тэмдэглэгээг хэрэглэдэг. (МУИС- д ашиглагддаг үнэлгээний нэмэлт тэмдэглэгээ)
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн хувьд оюутнуудын мэдлэг, чадварыг үнэлэхэд хэрэглэж буй үнэлгээний төрлүүд болон даалгавар боловсруулах зарчмын хэрэглээ, дүн шинжилгээ ба чанарын хийдэг. Үүнд: нэгж хичээлийн эхэнд оношилгооны сорилго, нэгж хичээлийн явцад ахиц дэвшлийг шалгах сорилго, нэгж хичээлийн явцад өөрийн болон оюутан, оюутнаа үнэлэх зэргийг дурьдаж болно.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Оюутны хандлагыг хэрхэн үнэлэх талаарх мэдээлэл байхгүй байна.

## **Зөвлөмж:**

- Үнэлгээний шалгуурын хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдуулж боловсруулах

## **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын орчин материаллаг баазын хувьд бүрэн хангагдсан.
- Хөтөлбөрт хамрагдаж буй тэнхимийн харъяа анги танхимууд ухаалаг самбар, прожектороор бүрэн тоноглогдсон анги бүр интернетэд холбогдсон.
- Багш нар орчин үеийн компьютер, чанга яригч, сургалтын шинэ техник, технологи ашигладаг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн багш оюутнууд хэрэглэхэд боломжтой “Cloud print” хэвлэлийн үйлчилгээний системийг хэрэглэдэг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч сургууль нь дууны хэт авианы зураг авах аппарат (Ultra sound images), нүдний хөдөлгөөн уншигч (Eye tracker) төхөөрөмжөөр тоноглогдсон хэлний туршилт судалгааны төвтэй.
- Оюутнууд синхрон орчуулгын дадлага хийх бүхээг бүхий тохижуулсан ангитай.

#### **Анхаарах асуудал:**

- Анги танхимын цэвэрлэгээ, тоноглолын ажиллагаа, агааржуулалт, халаалт дээр анхаарах

## **Зөвлөмж:**

- Анги танхимд сууж, хичээл даалгавараа хийх, тоног төхөөрөмжтэй ажиллахтай холбоотой дагаж мөрдөх журмыг боловсруулах
- Суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд тулгуурлан анги танхим, сургуулийн орчны засвар үйлчилгээг төсөвт суулгаж төлөвлөх

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн багш нар сургалтын ажлыг зохион байгуулах тогтсон төлөвлөгөө графикийн дагуу ажилдаг.
- МУИС-ийн СиСи систем, Microsoft teams, Zoom, Outlook office зэрэг сургалт судалгааны программыг багш, сурган хүмүүжүүлэгчид бүрэн эрхтэйгээр ашигладаг.
- Хичээлийн жил бүр тухайн хичээлийн жилийн сургалтын нэгтгэсэн төлөвлөгөөг агуулсан “Багшийн ажлын дэвтэр” хөтөлдөг.
- Магадлагдаж буй хөтөлбөрийн 21 хичээлийг цахим хичээлийн багц материалыг бэлтгэж сургалтандаа ашигладаг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалт болон эрдэм шинжилгээний ажилдаа СиСи системийг өргөнөөр ашиглаж хэвшсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын шинэлэг техник технологийг тухайн хөтөлбөрийг дэмжигч байгууллагууд болон хувь хүнтэй хамтран ажиллах гэрээ санамж бичиг байгуулах тал дээр анхаарч ажиллах

**Зөвлөмж:** Багш нарын боловсруулан туршсан цахим Е хичээлтэй болох хэрэгтэй байна. Teams программ, Си Си дээр байршуулсан файлуудыг бүрэн цогц цахим платформ хэрэглэгдэхүүнтэй, бүрэн цахимжсан хэмээн тооцоход хангалтгүй байгаа тул энэ тал дээрээ илүү анхаарч ажиллах хэрэгтэй юм.

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн сурах бичиг, судалгаа шинжилгээний ном бүтээлийн хүртээмж сайн.

- Номын сангийн (<http://library.num.edu.mn>, <http://catalog.num.edu.mn/>) цахим каталогт хөтөлбөрийн багш, оюутнууд өргөн ашиглаж болохуйц эрдэм мэдээллийн сантай.
- ШУС, ХУС-ийн санхүүжилтээр Oxford university press-с эрхлэн гаргадаг “Navigate” coursebook B1, B2, C1, C2, Q3-E-SB, Q3-TB номнуудыг оюутнуудын хэрэгцээнд зориулан бүрэн эрхтэй нь худалдан авч бүх эх хэлбэрээр нь сургалтанд хэрэглэж байна.
- Оюутнуудаас ном сурах бичгийн хэрэгцээ, сэтгэл ханамжийн судалгааг байнга авч ном сурах бичгийн сурах бичгийн баяжуулалт, сайжруулалт дээр анхаарч ажилладаг.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн номын сан 390.000 гаруй хэвлэмэл болон цахим бүтээлийн сан хөмрөг бүхий олон улсын цахим мэдээллийн сангуудыг ашиглах боломжтой номын сантай бөгөөд үүгээр хөтөлбөрийн багш оюутнууд байнга үйлчлүүлдэг.
- Тус хөтөлбөрийн оюутнууд хэрэглэх боломжтой ном, сурах бичиг, хэрэглэгдэхүүний жагсаалтыг жил тутамд гаргаж судалгаа хийдэг.
- Их Британи, Америк судлалын тэнхимийн дэргэд бүрэн бүртгэж каталогжуулсан 4000 орчим номын фондтой бөгөөд тэдгээрээс оюутнууд гэрээр авч унших боломжоор хангагдсан.

### **Анхаарах асуудал:**

- Багш нар хичээлийн үндсэн сурах бичиг бүтээх, багаар хамтран ажиллах тал дээр анхаарч ажиллах

### **Зөвлөмж:**

- Суралцагчдын номын сангаар үйлчлүүлэх давтамж, сэдлийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ном сурах бичгийн төрлийг нэмэгдүүлэх, ялангуяа цахим хэлбэрээр унших боломжийг эрэлхийлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүний чухал хэсэг болох мэргэжлийн ном сурах бичгийн баяжилт, шинэчлэлт, хүрэлцээ хэрэглээний талаар багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчдоос хэрэгцээний судалгаа авах

## **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хорооны журамыг МУИС-ийн захирлын 2016.12.23-ны өдрийн А 347 тушаалаар батлан 2017 оноос мөрдөж ажилласан байна.
- Хөтөлбөрийн хороо нь Хөтөлбөрийн Ерөнхий хороо, Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, тэнхмийн хөтөлбөрийн хороо, салбар дундын хөтөлбөрийн хороо гэсэн бүтэцтэйгээр ажилладаг байна.
- МУИС-ийн Хөтөлбөрийн хороо нь эрдмийн зөвлөл, үндсэн багш, сургалт эрхэлсэн захиргааны ажилтан, ажил олгогч, оюутны төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэйгээр сургалтын чанарт анхааран ажиллаж ирсэн байна
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим 5 хүний бүрэлдэхүүнтэй хөтөлбөрийн дэд хороог ажиллуулан МУИС-ийн Завхан, Орхон салбар болон үндсэн сургуулийн хэрэгжүүлэгч буй хөтөлбөрт дүн шинжилгээ хийж нэмэлт өөрчлөлт оруулсаар иржээ.
- Элсэлт, шилжилт, төгсөлт, мэргэжлийн хөтөлбөр сонголт, дүгнэх гэх мэт сургалтын үйл ажиллагаа удирдлагын Си Си системээр явагддаг учир дийлэнх журмын хэрэгжилтийг хянах боломж бүрдсэн.

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн Хөтөлбөрийн Хороо нь Ерөнхий, Суурь боловсролын, Салбар сургуулийн, салбар дундын төдийгүй хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимд хөтөлбөрийн дэд хороо ажилладаг нь онцлог болж байна
- Нийт 80 орчим утасгүй сүлжээний access point төхөөрөмжтэй.

##### **Зөвлөмж:**

- Сургалтын удирдлага, мэдээллийн СиСи системд сургалтын хөтөлбөр, бие даалтын ажлын төлөвлөгөө, хэрэглэгдэхүүнийг бүрэн гүйцэд оруулан тогтмол ажиллагаатай байлгахад анхаарах. Сургалтын чанарыг сайжруулахад ээлжит хичээлийн бэлтгэл төлөвлөлт чухал нөлөөтэй тул цааснаас татгалзсан өнөө үед цахимаар байршуулсан гэх нь зөв боловч шалгаж хандахад хэмжиж, үнэлэж болохуйц байх хэрэгтэй.

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

### **Илрэл, нотолгоо**

- Хамтын ажиллагаатай гадаадын 3: Саратовын их сургууль, АНУ ЭСЯ-ны англи хэлний сургалт хариуцсан алба, Саутвест Миннесоттагийн ИС-ийн профессор Дэвид Пикаскийн тэтгэлэг, дотоодын 7 : ШУА -ын ОУСХ, ГХЯ, ХНХЯ, МОНЦАМЭ агентлагийн гадаад мэдээний алба, МҮОНТ, Ийгл ТВ- тэй байгуулсан хамтын гэрээ хэрэгжиж хамтарсан олон үйл ажиллагаа явуулсан байна. Жишээ нь оюутан байхдаа дадлага хийж ТВ-ийн хүүхдийн кино орчуулан , төгсөөд тухайн байгууллагад ажилд орсон төгсөгч байна.
- Монгол угсаатан гадаад оюутанд тэтгэлэг олгох журам хэрэгжүүлдэг байна.
- Саратовын ИС-ийн ГХС-тай ЭША- аар хамтран тус сургуулиас зохион байгуулсан ОУЭШХ-д ИБАСТ-ийн багш нар тогтмол оролцон сүүлийн 5 жилд нийт 15 илтгэл хэлэлцүүлсэн байна.
- Нийт тэтгэлэг авсан оюутны тоо 70 байгаагаас орчуулгын хөтөлбөрийн 27 оюутан байна.
- МУИС-ийн 80 жилийн ойн ажлын хүрээнд тэнхмийн дэргэд Төгсөгчдийн холбоог байгуулан үйл ажиллагаа нь жигдрэн ажиллаж эхэлсэн байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн суралцагчдын тэтгэлэгийн төрлийг нэмэгдүүлж, шалгуур шаардлагыг тодорхой болгож нөхцөл хангасан ахисан түвшний суралцагч болон **Монгол угсаатан** гадаадын элсэгчдэд тэтгэлэг олгодог туршлагатай нь гадаад оюутны тоог нэмэгдүүлэх нэгэн боломж гэж үзлээ.

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн санхүүжилт сургуулийн нэгдсэн төсвийн хүрээнд зохицуулагддаг.
- Нэмэлтээр сүүлийн жилүүдэд Саутвест Миннесоттагийн ИС-ийн профессор Пикаски нийт 60 оюутанд 24000 долларын тэтгэлэг олгожээ.
- Тус профессорын нэрэмжит тэтгэлэгээс 2021 онд Ном сурах бичигт -29 999 949 87 төгрөг зарцуулжээ.

- Багш нарын эрүүл мэнд, эрдэм судлалын ажилд жил бүр оруулсан санхүүжилтийн баримт нотолгоотой танилцсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Ажил олгогчоос авсан судалгааны тайланг жил бүр гаргасан байсан.
- Мэдээлэлийг хэвлэмэл, цахим хэлбэрээс гадна хөтөлбөрийн танилцуулгыг видео хэлбэрээр хийж youtube- д байршуулсан бөгөөд сурталчилгааг ТВ, сонин, сэтгүүл, аймаг орон нутгийн удирдлага, ТББ зэргээр дамжуулан олон нийтэд хүргэдэг байна.
- Хөдөлмөрийн зах зээлийг тандах судалгааг ажил олгогчийн судалгаа, төгсөгчдийг мөшгөх судалгаагаар илрүүлсэн байна
- Мэргэжлийн хөтөлбөр сонгох ажиллагааг салбартаа амжилт гаргаж байгаа мэргэжилтнүүдтэй тодорхой сэдвээр цуврал уулзалт хийж туршлагаас нь сонсож, зөвлөгөө авдаг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхижүүлэлтээр 5, олон нийтэд сурталчлах 7 төрлийн үйл ажиллагааг явуулж ирсэн. Үүнд мэргэжил сурталчлах өдөрлөг, англиар илтгэл тавих уралдаан, спортын томоохон үйл ажиллагаа, ТВ, радио, цахим орчны зар сурталчилгааг өргөн ашигладаг.
- Мэргэжлийн, төрийн, төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоон гурван талт гэрээ хийж оюутны дадлага, хөдөлмөрлөх хүчний хэрэгцээний судалгаа хийх, хамтран тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлдэг байна.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Мэдээлэл технологийн газартай
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах дараах удирдлагын мэдээллийн системүүд ажилладаг. Үүнд:

- МУИС-ийн цахим <https://www.num.edu.mn/>
- МУИС-ийн элсэлтийн цахим хуудас <http://elselt.num.edu.mn/>
- МУИС-ийн бүртгэлийн нэгдсэн систем <http://burtgrl.num.edu.mn/negdsen>
- МУИС-ийн хөтөлбөр чанарын баталгаажуулалтын хэлтэс <http://hutulbur.num.edu.mn/>
- Удирдлагын мэдээллийн систем нь удирдах албан тушаалтнаас эхлэн захиргааны ажилтнууд, багш, алба нэгжүүдийн өдөр тутмын үйл ажиллагааны уялдаа, мэдээллийг шуурхай дамжуулахад зориулсан өндөр нууцлал, тусгай эрхээр нэвтрэн ашиглах боломжийг бүрдүүлсэн програмууд байна, гэхдээ оюутны хандалт шууд орохгүй гацаж байгааг анхаарах

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Элсэгчийг МУИС-ийн бүртгэлийн системд цахим хэлбэрээр бүртгүүлэх боломжоор хангасан ( [www.burtgel.num.edu.mn](http://www.burtgel.num.edu.mn)).
- 2015 оноос эхлэн бакалаврын өдрийн ангид элсэгчдийг бүрэлдэхүүн сургуульд бүртгэн элсүүлж ерөнхий суурийн багц хичээл судалсны дараа мэргэжлээ сонгох боломжоор хангах бодлого хэрэгжсэн.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар жилд 2 удаа хөтөлбөр сурталчлах өдөрлөг зохион байгуулдаг байна.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Элсэлтийн бодлого, дүрэм журмын дагуу цахим бүртгэлийн системээр бүртгэгддэг
- Улсын олимпиадад байр эзэлсэн болон оролцсон сурагч урьдчилан элсэх боломжтой
- Шинэ элсэгчдэд зориулсан чиглүүлэх 7 хоногийн сургалт өдөрлөг зохион байгуулдаг
- Элсэлтийн мэдээллийг сургуулийн цахим хуудас, цахим шуудан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон өөрийн биеэр ирж бүртгүүлэхэд өгнө.



- Элсэгчдэд зориулсан гарын авлагаа вебэд байршуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Элсэлтийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах
- Гадаад оюутантай болох боломж хайх

#### **Зөвлөмж:**

- Хос хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судлах

#### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Нийт 9 төгсөгч 3 ажил олгогчидтой уулзалт хийсэн (үүнээс 6 төгсөгч онлайнаар, 3 төгсөгч ирж уулзан санал солилцов).
- Дадлагын талаар хамтран ажиллах зарим гэрээг авч үзсэн
- СА –ны програмаас болон Төгсөгчдийн загвартай тайланд бичигдсэн байдлаар танилцсан
- МУИС-ийн Багш хөгжил, цахим сургалт төвийн “ Лекцийн зочин багш” хөтөлбөрийн хүрээнд нэрт орчуулагчт Акимтай “Орчуулгын онол практик сэдэвт “уулзалт хийсэн
- Work and Travel Mongolia ХХК жил бүр уулзалт зохион байгуулаж үйл ажиллагаагаа таницуулан оюутныг АНУ-д явуулж практик дадлага олгоход хамтран ажилласан байна
- Оюутнууд. Цахимаар тодорхой үйлчилгээг авах боломжтой. Үүнд: нийтийн тээврийн хөнгөлттэй зорчих карт, оюутны карт захиалах, тодорхойлолт, дүнгийн лавлагаа авах, байранд орох, шилжих, төгсөх хүсэлт гаргах, утасгүй сүлжээнд нэвтрэх эрх нээлгэх, сургалтын төлбөр төлөх зэрэг үйлчилгээнүүд орно.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Нийт 10 Орчим зөвлөн туслах үйлчилгээ явуулдаг
- МУИС-ийн индэр ажиллуулан нэрт эрдэмтэн алдар гавьятнуудтай уулзалт хийдэг
- Хөтөлбөрийн багш нар бие даалттай өдөрөө оюутанд зөвлөлгөө өгдөг

#### **Зөвлөмж:**

- Оюутнууд суралцах хугацаандаа дадлага ажил 1 удаа хийх нь хангалтгүй гэж төгсөгч санал хэлсэнтэй уялдуулан зөвлөхөд 2 удаа хийлгэж , танилцах болон орчуулгын гэж 2 дадлага хийх боломжийг бүрдүүлбэл хөтөлбөрөөр суралцагчдын ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд нь тустай юм.

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн хэмжээнд өмнөх хичээлийн жилд оюутны дунд нийт 69 клуб ажилласан байна.
- Оюутнууд сайн дурын ажилд идэвхитэй оролцдог байна. Жишээ нь
- Uncage клубын сайн дурын ажилтан, Talented клубын гишүүн, Num volunteer club – д үндсэн гишүүн, "Этүгэний аялгуу" сургалтын төвд морин хуур хөгжмийн сургагч багшаар тус тус ажилладаг байна
- Цагийн ажил болон үндсэн ажилд зуучлах Career & Job Fair өдөрлөгийг жил бүр зохион байгуулдаг уламжлал тогтсон.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш, оюутны төвийн эрхлэгчийн танилцуулснаар: Тус төв нь өөрийн гэсэн байртай тэнд олон төвүүд үйл ажиллагаа явуулж байна, жишээ нь: эрүүл мэндийн төв, сэтгэл зүйн сорилын төв, start up- хамтын оффис, фитнесийн төвүүд нь суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжиж, сайн дурын ажлуудыг хамтран явуулдаг байна.
- Номын сан орчин үеийн өндөр технологиор тоноглогдсон, оюутны эрдэм шинжилгээний ажил, олон нийтийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажилладаг бөгөөд уншлагын заал олонтой тул суралцах, судалгаа хийх бүх нөхцөл хангагдсан байна.

### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөн жилд 2 удаа зохих журмын дагуу явагддаг

- Хичээл дүйцэлт МУИС –ийн сургалтын бодлого дүрэм журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Сурлагын амжилтаар улирч, хасагдах хөдөлгөөн нэмэгдүүлэхээс сэргийлэн анхаарах

#### **Зөвлөмж:**

- Зөвлөх багш сурлагын амжилтанд нөлөөлөх үйл ажиллагаа зохион байгуулан зөвлөгөө өгч төлөвлөн ажиллах

### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Гадаад хэлний орчуулга (Англи хэл) хөтөлбөрийн төгсөгчийн загварыг оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусган гаргасан байна .
- Төгсөлтийн баримт бичгийг олгох тогтсон дүрэм журамтай
- СА –ны програмд дүнг нэгтгэдэг, Төгсөлтийн баримт бичгийг загвар, журмын дагуу бүрдүүлдэг байна
- Төгсөлттэй хамааралтай бүх материалыг архивлах журамтай.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчийг диплом бичих, онол арга зүйд сонирхолтой, бичгийн өндөр соёлтой болоход чиглүүлэн туслахад анхаарах, учир нь төгсөх курсын оюутны төлөөлөлтэй хийсэн уулзалтаар энэ хаврын төгсөгчид дипломын ажил бичиж буй оюутан байхгүй гэсэн хариулт өгөв.

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

## **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогыг баримт бичиг бүрэн хийгдсэн, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан бүх багш нар тэнхимийн түвшинд хангалттай хийгджээ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нийт багшийн 25% нь эрдмийн зэрэг цолтой, дэд профессорын зэрэглэлд 25%, ахлах багшийн зэрэглэлд, 60% ахлах багшийн зэрэглэлд, 15% багшийн зэрэглэлд ажиллаж байгаагаас 8 багш МУИС-ийн доктрантурт суралцан судалгааны ажил бичиж байгааг баримт нотолгоогоор баталгаажууллаа.
- Тус сургуулийн “Стратегийн төлөвлөгөө” алсын харааны дагуу багшлах шилдэг боловсон хүчнийг бүрдүүлэн ажилладаг.
- Бакалаврын сургалтын семинар, дадлагын хичээлийн бүлгийг дунджаар 25 сурагчаар зохион байгуулна хэмээн заасан байдаг бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын хувьд нэг багшид дундажаар 19 оюутан ноогдож байна.
- Багш нарын зэрэг цол зэргийг харгалзан тэдний цагийн ачааллыг тооцоолон нарийн судалгаа хийдэг.
- Багш нарын А,Б,В цагийн гүйцэтгэл өөрийн үнэлгээний тайланг үндэслэн урамшууллыг олгодог.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн “Багшийн хөгжил цахим сургалтын төв” багш нарын заах арга зүйг дээшлүүлэх зорилгоор орчин үеийн чиг хандлага, олон улсын түвшинд нийцсэн сургалт, судалгааны үйл ажиллагаа зохион байгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Дотоод гадаадын төстэй их сургуулиудтай хамтарсан салбар дундын судалгааг хэрэгжүүлэх тал дээр анхаарах

**Зөвлөмж:** Цаашид судалгааны их сургуулийн гол шалгуур болох эрдмий зэрэгтэй багш нарын тоо, эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Багш нарын А,Б,В цагийн гүйцэтгэл өөрийн үнэлгээний тайланг үндэслэн урамшууллыг олгодсон байдлыг илүү нарийвчлан баталгаажуулж нотолгоог хавсарган хадгалдаг болох хэрэгтэй.

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр хэрэгжилтийн хугацаанд нийт багш нарын 6 нь заах арга зүй, 2 багш гадаадад мэргэжил дээшлүүлсэн бол 5 багш өөрийгөө хөгжүүлэх сургалтад хамрагдсанаар тэдний багшлах болон судалгааны ур чадварт сайнаар нөлөөлсөн байна.
- Багш нар гадаадын санхүүжилттэй 3 төсөл, дотоодын санхүүжилттэй 7 төсөл, 4 гэрээт ажилд удирдагч болон гүйцэтгэгчээр оролцсон нь чамлахааргүй үзүүлэлт хэмээн үзлээ.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн багш ажилтны үйл ажиллагааг дэмжих зардлын дагуу багш нарт мөнгөн тэтгэмж жил бүр олгодог нь тэдний аятай тухтай ажиллах боломж боллоцоог олгодог.

#### **Анхаарах асуудал:**

- Тэнхимийн багш нарыг хөгжүүлэх бүтээлч ажлын төлөвлөгөөг тус бүрээр эмхэтгэн гаргаж төлөвлөгөө тайлангийн биелэлтийн хувийг нарийвчлан гаргаж тооцдог байх

#### **Зөвлөмж:**

- Багшлахуйн болон судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгааг нарийвчлан гаргаж багшийн хөгжлийн хөтөлбөртэй болох хэрэгтэй.

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Нийт багш нарын эрдэм шинжилгээний ажлыг нэгтгэн дүгнэвэл олон улсад 41, улсын хэмжээнд 21, хянан тохиолдуулсан ном сурах бичиг гарын авлага 12, нэг сэдэвт бүтээл 2, хэвлүүлсэн сурах бичиг ном гарыг авлага 8, орчуулсан ном сурах бичиг 4-ийг туурвисан байна.
- Багш нар өөрийн эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөг *research.num.edu.mn*-д байршуулж, тус сургуулийн эрдэм шинжилгээний алба хянаж үнэлдэг.

- Багш Г.Сайнбаяр, М.Даариймаа нар “Web of Science”, “Scopus” мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд бүтээлээ хэвлүүлсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС нь судалгааны суурь зардлыг профессор цолтой багш нарт 2000000, доктор зэрэгтэй багш нарт жил бүр 1000000 төгрөг олгож байгаа нь тэдний эрдэм шинжилгээ ажил хийхэд хувь нэмэр оруулж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөг цахимд байршуулж баталгаажуулахын зэрэгцээ цаасан хэлбэрээр авч жил жилийн тайланд хавсаргах хэрэгтэй хэмээн үзлээ.

#### **Зөвлөмж:**

- Нэг сэдэвт бүтээл туурвих, тэнхимээс гаргасан бүтээлийг оюуны өмчөөр баталгаажуулах хэрэгтэй юм.

### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш бүрийн үнэлгээг МУИС-ийн дотоод сүлжээ болох СиСи систем ашиглан хичээл судалсан оюутнууд, тэнхимийн эрхлэгч нар дүгнэдэг.
- Хөтөлбөрийн багш бүр багшийн мэдээлэл, ажлын ноогдол, боловсруулсан хичээлийн тодорхойлолт, хөтөлбөр, танилцуулга, боловсролын гэрчилгээ, мэргэжил дээшлүүлсэн байдлыг нотлох баримтууд, тушаалын хуулбар, гэх мэт агуулгыг багтаасан хавтастай.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байх
- Багшийг үнэлсэн баримтыг баталгаажуулах
- Урамшуулал олгосон баримтын хавсаргах
- Хангалтгүй үнэлгээ авсан багш нарт авч хэрэгжүүлсэн ажил түүний үр дүнгийн талаар мэдээлэл нэгтгэх

### **Зөвлөмж:**

- Багш бүр жилд хийсэн ажлаа өөрийн үнэлгээний тайлангийн дагуу үнэлж, хөндлөнгийн үнэлгээтэй харьцуулан хоорондын матриц дээр анализ дүн шинжилгээ хийх

### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

### **Илрэл нотолгоо:**

- 2015 онд МУИС-ийн захирлын А/203 тоот тушаалаар батлагдсан МУИС-ийн Сургалтын журмыг баталсан. Энэ журам нь сургалтын хөтөлбөр болон түүний оролцогч талуудын эрх, үүрэг, сургалт явагдах процесс зэрэг цогц асуудлыг бүрэн тусгасан боловч хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын үндсэн ойлголт, хэрэгжүүлэх, үнэлэх, дүгнэх процесс хараахан тусгагдаагүй байна
- Хөтөлбөрийн хороод нь анхан шатанд Тэнхимийн хөтөлбөрийн хороо (ТХХ), дунд шатанд Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо (БСХХ), дээд шатанд хөтөлбөрийн ерөнхий хороо (ХЕХ) гэсэн шатлалтай үйл ажиллагаа явуулна. МУИС-н бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурь хичээлийн хөтөлбөр түүний чанарын үнэлгээг хариуцсан Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо (ЕСХХ)-той.
- Тэнхимийн хөтөлбөрийн хороо нь сургалтын хөтөлбөрт хийх өөрчлөлтийн талаар санал гаргаж, шийдвэрлүүлэх боломжтой (Үүнд, өөрчлөлт оруулах, шинэ хичээл санал болгох, сургалтын хөтөлбөрийн журамд санал оруулах, сонгон судлах хэсэгт санал оруулах, ерөнхий суурийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх)
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хариуцсан нэгжтэй бөгөөд хөтөлбөрүүдийн дотоод хөндлөнгийн үнэлгээг хийж, санал зөвлөмж гарган шийдвэрлэдэг.
- Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт нь тухайн хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүнг хангасан байдлыг 1) үнэлэх, 2) цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлоход чиглэгдэнэ гэж тодорхойлсон.

- Дунд шатны хөтөлбөрийн хороо нь хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд нөлөөлөхгүй өөрчлөлт (сургалтын төлөвлөгөөний мэргэших сонгон судлах багцад хичээл нэмэх, хасах, мэргэжлийн суурь болон мэргэших заавал судлах хичээлийн 25% хүртэлх агуулгын өөрчлөлт, хичээлийн уялдаа холбоо, хичээлийн судлах улирал солих)-ийг хийж болох ба холбогдох шийдвэрийг хөтөлбөр хариуцсан захиргааны нэгжид хүргүүлнэ.
- Сургалтын хөтөлбөр нь хөтөлбөрийн хөгжлийн төлөвлөгөөтэй байж түүний хэрэгжилтийг үнэлж, дүгнэдэг байна (5.1.5) гэж заасан байна.
- Өөрийн үнэлгээнд оролцогч тал болон тэдгээрийн хийх ажлыг агуулга, давтавж, түүнийг тайлагнах нэгжүүдийн хэлбэрийг тодорхой тусгасан. Жишээлбэл, Багш-сургалтын болон сургалтаас гадуурх үйл ажиллагаа, тэнхимийн стратеги төлөвлөгөө, хөтөлбөр хичээлийн суралцахуйн үр дүн, хөгжлийн төлөвлөгөөнд үзүүлж буй нөлөөг жил бүрт тэнхимийн хөтөлбөрийн хороонд тайлагнадаг.
- Дотоод хөндлөнгийн үнэлгээ нь агуулгын хувьд 4 дэд хэсгээс бүрдэнэ. Суралцахуйн үнэлгээ, Багшлахуйн үнэлгээ, Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, Орчин нөхцлийн үнэлгээ

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Дотоод чанарын баталгаажуулалт хийх механизмыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн боловч үйл ажиллагааг нь бүрэн жигдрээгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Дотоод чанарын баталгаажуулалтыг тэнхим, нэгжээс нарийн зохион байгуулалттай эхлүүлэх, тэнхимийн хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх

#### **Шаардлага:**

- Чанарын баталгаажуулалтын чиглэлээр ажиллаж буй албатай нягт уялдаатай ажиллаж, хөтөлбөр хөгжүүлэлт болон чанарын баталгаажуулалтыг тогтмол хийж, улмаар үр дүнг үйл ажиллагаа болгох

### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

#### **Илрэл нотолгоо:**



- 2013-2014 оноос “Мэргэжил”-ийн сургалтын уламжлалыг халж, зах зээлийн нийгэмд хөрвөх чадвартай дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, дээд боловсролын зэрэг олгох хөтөлбөрийг анх удаа бүрэн утгаар нь хэрэгжүүлж эхэлсэн.
- СиСи програм дээр судалгаа авдаг, суралцагчийн сэтгэл ханамж, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа зэрэг цогц судалгаа хийдэг байна.
- СиСи програмаар багш, сургалт, сургалтын орчны талаар улирал бүр судалгаа авдаг.
- 2021 онд Гадаад хэлний салбарын багш нар хамтран төгсөгчийн сэтгэл ханамжийг судалгаа боловсруулсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцагч, төгсөгч, ажил олгогчдыг хамруулсан иж бүрэн судалгааг байнга зохион байгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Иж бүрэн судалгаа хийж байгаа боловч түүний мөрөөр хийгдэж байгаа ажлууд нь тодорхой бус.

#### **Зөвлөмж:**

- Иж бүрэн судалгааг зохион байгуулж, жил бүр тайлагнаж байгаа нь судалгааны хангалттай сан бүрдүүлж байна. Үүнийг ашиглан тэнхим, нэгж бүр судалгааны мөрөөр хийсэн ажлыг тайлагнадаг болох хэрэгтэй.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС нь БМИҮЗ-н удирдах зөвлөлийн 2018.06.26 ны өдрийн 29 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.
- МУИС-н захиргааны бүтцэд хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хариуцсан Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс байгуулагдсан нь хөтөлбөрийг нэгдсэн зохион байгуулалтаарх хангах, хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээ хийх, холбогдох дүрэм журмыг боловсруулах боломж бүрдсэн.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь гадаад хэлний орчуулагч (англи хэл) хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрөөр анх удаа магадлан итгэмжлэл хийлгэж байна.

- Хөтөлбөрийн агуулга, аргагүйг сайжруулах зорилгоор ижил төрлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг гадаад болон дотоодын их сургуулиудын хөтөлбөртэй харьцуулалт хийж, цаашид хэрхэн сайжруулах талаар анхааран ажиллаж байна.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг тэнхимийн хүрээнд 2018 болон 2021 онд хийж, үр дүнг боловсруулсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх тал дээр анхааран ажиллах

#### **Шаардлага:**

- Чанарын баталгажуулалтын тогтолцоог байнгын үйл ажиллагаанд оруулах

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан**

## ДҮГНЭЛТ

Гадаад хэлний орчуулга /англи хэл/ хөтөлбөр

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	3			
4	Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт	5			
5	Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	5			
6	Багшлах бүрэлдэхүүн	4			
7	Чанарын үнэлгээ баталгаажилт	1	2		
	Нийт	24	2		
<b>Дүгнэлт</b>		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Их Британи, Америк судлалын тэнхимийн “Гадаад хэлний орчуулга (англи)” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... Н.Оюунцэцэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Р.Наранцэцэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Ж.Ганцэцэг

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Сургуулийн нэр	МУИС, ШУС
Хөтөлбөрийн нэр	Гадаад хэлний орчуулга /англи/
Хөтөлбөрийн индекс	023102
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>- Олон улсад хэрэгжиж буй ижил төрлийн хөтөлбөрүүдтэй харьцуулах</li> <li>- Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сайжруулах</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнг сайжруулах</li> <li>- Лабораторид түшиглэн орчуулгын хичээлийг орчин үеийн технологитой уялдуулж зохион байгуулах</li> <li>- Үнэлгээний шалгуурын хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнтэй уялдуулах</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>- Төгсөгчдийн болон оюутнуудтай хийсэн уулзалтаас дүгнэхэд үндсэн сурах бичгийг шинэчлэх, анги танхим, сургуулийн орчинд засвар үйлчилгээг хийх</li> <li>- Анги танхимд сууж хичээллэх, тоног төхөөрөмжтэй ажиллахтай холбоотой дагаж мөрдөх журам боловсруулах</li> <li>- Ээлжит хичээлийн и-контентийн агуулгыг хүртэхүйц, харагдахуйц, хэмжиж болохуйц, үнэлж болохуйц байхад анхаарах</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын удирдлага, мэдээллийн СиСи системд сургалтын хөтөлбөр, бие даалтын ажлын төлөвлөгөө, хэрэглэгдэхүүнийг бүрэн гүйцэд оруулан тогтмол ажиллагаатай байлгахад анхаарах. Сургалтын чанарыг сайжруулахад ээлжит хичээлийн бэлтгэл төлөвлөлт чухал нөлөөтэй тул цааснаас татгалзсан өнөө үед цахимаар байршуулсан гэх нь зөв боловч шалгаж хандахад хэмжиж, үнэлэж болохуйц байх хэрэгтэй.</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Цаашид хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой тэнхимийн албан баримт бичгийн бүрдүүлэлтийг баримтжуулан, архивлахад анхаарах</li> <li>- Тус хөтөлбөрөөр элсэгчдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах</li> <li>- Хос хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг судлах</li> <li>- Дадлага хийх хугацааг нэмэгдүүлэх</li> </ul>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- МУИС-н Багш хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн ажлын төлөвлөгөө, тайлан нь өөрийн үнэлгээний тайланд тодорхой бус байгааг анхаарах</li> <li>- Багш, оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажлыг идэвхжүүлэх, эрдмийн зэрэг цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтад оролцогч талуудыг хамруулсан сэтгэл ханамжийн судалгааг сургуулийн хэмжээнд байнга зохион байгуулдаг ч түүний мөрөөр хийгдэж буй ажил өөрийн үнэлгээ тайлан болон уулзалтуудаас тодорхой харагдахгүй байгааг анхаарах</li> </ul>

	- Хөтөлбөрийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх тал дээр анхааран ажиллах
<b>ШААРДЛАГА</b>	
	<ul style="list-style-type: none"> <li>- МУИС дээр хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтэс 2018 онд байгуулагдаж ажиллаж байгаад 2022 онд Сургалт, хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын бодлогын газар болон өөрчлөгдөж, 2023 оноос хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтын журам мөрдөгдөж эхэлжээ. Одоогоор хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хийх төлөвлөлт хийгдэж байгаа тул цаашид дотоод чанарын баталгаажуулалт цогц байдлаар хийгдэх боломж бүрдэнэ гэж найдаж байна.</li> <li>- Чанарын баталгаажуулалтыг тэнхимийн хөтөлбөрийн хорооноос эхлэн тогтмол зохион байгуулж, оролцогч талуудын хэрэгцээг тусгаж, хөтөлбөрийн өрсөлдөх чадамжийг дотоод болон гадаад зах зээл дээр нэмэгдүүлэх шаардлагатай</li> </ul>

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Н. Оюунзаяа	Ахлах багш	Магистр		Орчуулга
2	Э. Ундраа	Багш	Магистр	20	Орчуулга, англи хэл
3	Д. Түвшинтөгс	Багш	Магистр		Уран зохиолын орчуулга

Мөн тэнхимийн хөтөлбөрийн хорооны 5 багштай уулзаж, ярилцсан. Р. Батсүрэн, Ц. Оюунсүрэн, Ж. Эрдэнэбат, Т. Отгонсүрэн, Ц. Энхмаа

##### II. Оюутны нэрс

	Овог	Нэр	ID	Төлөв	Хэлбэр	Түвшин
1	Билэгт	Баярт	18B1NUM0349	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	4-р түвшин
2	Батбаатар	Болор-Эрдэнэ	19B1NUM1596	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	4-р түвшин
3	Эрдэнэбаатар	Булганчимэг	22B1NUM0909	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	4-р түвшин
4	Жаргалсайхан	Солонго	18B1NUM3476	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	4-р түвшин
5	Ганзориг	Төгөлдөр	19B1NUM0060	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	4-р түвшин
6	Нямаа	Энхболор	19B1NUM0715	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	4-р түвшин
7	Батсайхан	Эрдэнэхөлөг	19B1NUM0906	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	4-р түвшин
8	Эрдэнэбилэг	Амар	20B1NUM1531	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин
9	Батжаргал	Ариунмаа	19B1NUM1371	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин
10	Цэдэнбал	Билэгт	22B1NUM0910	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин

11	Энхбаяр	Гүнжидмаа	20B1NUM1290	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин
12	Хумар	Жанерке	20B1NUM0770	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин
13	Батсүрэн	Өнөржаргал	20B1NUM1866	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин
14	Батмөнх	Пүрэвдолгор	16B1SAS1359	Идэвхтэй сурч байгаа	Хос	3-р түвшин
15	Эрдэнэбаяр	Пүрэвсүрэн	20B1NUM1243	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин
16	Буянтогтох	Тэмүүлэн	19B1NUM1649	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин
17	Ганбат	Эрдэнэжаргал	20B1NUM0203	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	3-р түвшин
18	Серекбай	Жанаргүл	21B1NUM1617	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	2-р түвшин
19	Амарбаян	Золзаяа	21B1NUM1450	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	2-р түвшин
20	Ганзоригт	Мөнхзул	20B1NUM2517	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	2-р түвшин
21	Даваасамбуу	Тэмүүжин	21B1NUM1578	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	2-р түвшин
22	Чинзориг	Чинхүслэн	21B1NUM1507	Идэвхтэй сурч байгаа	Үндсэн	2-р түвшин

### III. Ажил олгогчдын нэрс

	Овог, нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Баасандорж	Оюун-Ухааны академи	Дэд захирал
2	Н. Хонгорзул	Селена Травел	Менежер
3	Т. Анар	Wallstreet	Борлуулалт хариуцсан менежер

### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог	Нэр	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Ганбаатар	Золжаргал	2018	Сургалтын төв	Багш
2	Энхбаатар	Хонгорзул	2018		
3	Цогбадрах	Отгонбаяр	2019	Оюу толгой	Орчуулагч
4	Батхуяг	Ариунжин	2020	Гэгээ академи	
5	Батболд	Жамбалсүрэн	2020	Орчуулагч	Орчуулагч
6	Баяр	Оюунханд	2021	Орчуулагч	Орчуулагч
7	Эрдэнэчимэг	Энхгэрэл	2021	Монгол телевиз	Орчуулагч
8	Цэрэннадмид	Батням	2021	Focus сургалтын төв	Багш
9	Баасанжав	Эрдэнэсүвд	2022	Wallstreet сургалтын төв	Багш орчуулагч
10	Бат-Орших	Янжинлхам	2022	Австралид суралцаж байгаа	

11	Түвшинжаргал	Мичидмаа	2022	МУИС	Гадаад оюутан хариуцсан мэргэжилтэн
----	--------------	----------	------	------	-------------------------------------

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
*/албан бичгийг оруулах/*



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
**ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ**

14201 Улаанбаатар хот-46а ш/х-330, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 47, Утас/Факс: (976-11) 32-54-35,  
E-mail: sas@num.edu.mn, http://sas.num.edu.mn

2022.06.06 № 78/682

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журмын дагуу тус сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Их Британи, Америк судлалын тэнхимийн Гадаад хэлний орчуулга /Англи/ бакалаврын хөтөлбөрт ажилласан шинжээчийн багийн эцсийн тайланг илгээсэн та бүхэнд талархал илэрхийлж байна.

Их Британи, Америк судлалын тэнхимийн магадлан итгэмжлүүлэх өөрийн үнэлгээний багийн хамт олон тус тайлантай танилцаж, түүнд орсон анхаарах асуудал, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна.

ИХ БРИТАНИ, АМЕРИК  
СУДЛАЛЫН ТЭНХИМИЙН  
ЭРХЛЭГЧ



Р.БАТСҮРЭН

142308612